



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 645

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамарах хөдлөх хөрөнгийн дуудлага худалдааны талаар авах арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дугаар тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Татварын ерөнхий газрын харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй нийт 109,800,000.00 (нэг зуун есөн сая найман зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 3 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, харьяа байгууллагуудын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1 Үндсэн хөрөнгийг дуудлагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2 Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээг) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг батлагдсан маягтын дагуу гарган 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001297



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 64 дугаар тогтоолын хавсралт

Татварын ерөнхий газрын харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тээврийн хэрэгсэл

Д/д	Автомашини марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/	Эзэмшигч байгууллага
1	Ниссан навара маркийн 16-36 ХӨВ улсын дугаартай, суудлын автомашин Арлын дугаар - MNTCCUD40Z0601261,	2012/2013	85689	47,800,000.00	47,800,000.00	0.00	1,500,000.00	500,000.00	Хөвсгөл аймгийн Татварын хэлтэс
2	Ниссан навара маркийн 51-15 БУЛ улсын дугаартай, суудлын автомашин Арлын дугаар - MNTCCUD40Z0601344,	2013/2013	97237	44,000,000.00	44,000,000.00	0.00	1,000,000.00	500,000.00	Булган аймгийн Татварын хэлтэс
3	Соната-6 маркийн 00-18 БУЛ улсын дугаартай, суудлын автомашин Арлын дугаар - KMNET41B3BA207544	2006/2013	243722	18,000,000.00	18,000,000.00	0.00	1,000,000.00	500,000.00	Булган аймгийн Татварын хэлтэс
				109,800,000.00	109,800,000.00	0.00	3,500,000.00	1,500,000.00	
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			109,800,000.00 (нэг зуун есөн сая найман зуун мянган)	109,800,000.00 (нэг зуун есөн сая найман зуун мянган)		3,500,000.00 (гурван сая таван зуун мянга)	1,500,000.00 (нэг сая таван зуун мянга)	